

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн А/258 дугаар
тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2024 он

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

БАРАА ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕР
ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын
нэр:

Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах

Тендер
шалгаруулалтын
дугаар:

ЭХЭМҮТ/20240102009

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ).....	5
1. Тендерийн цар хүрээ.....	5
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг.....	5
3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж.....	5
4. Сонирхогч этгээд, оролцогч.....	6
5. Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ.....	6
6. Нийлүүлэх барааны гарал үүсэл.....	7
7. Тендер шалгаруулалтын баримт бичиг.....	7
8. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах.....	7
9. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт.....	7
10. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл.....	8
11. Тендерийн иж бүрдэл.....	8
12. Тендерийн жишиг маягтууд.....	9
13. Хувилбарт санал.....	9
14. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг.....	9
15. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг.....	10
16. Чадавхын болон туршлагын шаардлага.....	11
17. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт.....	12
18. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ..	13
19. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт.....	13
20. Тендерийн валют.....	14
21. Тендер хүчинтэй байх хугацаа.....	14
22. Тендерийн баталгаа.....	14
23. Тендер баталгаажуулах, илгээх.....	14
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа.....	15
25. Тендерийн талаар тодруулга авах.....	15
26. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх.....	15
27. Тендерийг үнэлэх.....	15
28. Арифметик алдааг залруулах.....	16
29. Оролцогчид давуу эрх олгох.....	16
30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт.....	16
31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох.....	16
32. Тендерийг эрэмбэлэх.....	16

33.	Оролцогчийн чадавхыг дахин магадлах	16
34.	Мэдэгдэл хүргүүлэх	17
35.	Гүйцэтгэлийн баталгаа.....	17
36.	Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах.....	17

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ
 - 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “бараа” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.
 - 1.3. Барааг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой багцын барааг хуулийн 8.1-д зааснаар дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой бол энэ тухай захиалагч өгөгдлийн хүснэгтэд заана. Ийнхүү заасан бол тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ.
 - 1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.
2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг
 - 2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.
3. Худалдан ажиллагааны тогтоомж авах хууль
 - 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
4. Худалдан ажиллагааны систем авах цахим
 - 4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

- 5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
- 5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.
- 6. Сонирхогч оролцогч этгээд,**
- 6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
- 6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
- 6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
- 6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
- 7. Түншлэлийн туслан гэрээ болон гүйцэтгүүлэх гэрээ**
- 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
- 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- 7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
- 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

- 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 8. Нийлүүлэх барааны гарал үүсэл** 8.1. ТШЗ-ны 1.3-т өөрөөр заагаагүй бол гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно.
- 9. Тендер шалгаруулалтын баримт бичиг** 9.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл.
- 9.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 9.3. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
- 10. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах** 10.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.
- 10.2. ТШЗ 10.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.
- 10.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт** 11.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана. Захиалагч уулзалтад ТШЗ-ны 6.6-д заасан сонирхогч этгээд, түүний төлөөллийг оролцуулна.

- 11.2. ТШЗ-ны 11.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 12.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны 12.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.
- 12.4. Захиалагч ТШЗ-ны 12.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн бараа нийлүүлэх техникийн болон үнийн санал байна.
- 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.2.1. ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
- 13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
- 13.2.3. захиалагч зөвшөөрсөн бол ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

- 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
- 13.2.5. санал болгож буй бараа ТШЗ-ны 17 дугаар зүйлд заасан тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
- 13.2.6. бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 13.2.7. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 18, ТШЗ 19, ТШЗ 20 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
- 13.2.8. ТШЗ-ны 21 дүгээр зүйлд заасан барааны үнийн задаргаа;
- 13.2.9. ТШЗ-ны 21.9-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
- 13.2.10. түншлэл бол хуулийн 6.3-т заасан түншлэлийн гэрээ.
- 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
- 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 14. Тендерийн маягтууд** **жишиг** 14.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтын дагуу илгээнэ.
- 15. Хувилбарт санал** 15.1. Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.
- 16. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг** **баримт** 16.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.
- 16.2. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ.
- 16.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.4. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 14.2, 14.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

17. Санал болгож буй бараа тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

17.1. Нийлүүлэхээр санал болгох барааны гарал үүслийн мэдээллийг V бүлгийн **Error! Reference source not found.**-ын холбогдох хэсэгт бөглөж ирүүлнэ.

17.2. Хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.

17.3. Оролцогчийн санал болгож буй бараа нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар тендерт ирүүлнэ.

17.4. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож байгаа бараанд холбогдох загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилтыг хийх ажиллагаанд оролцогчийг өгөгдлийн хүснэгтэд зааснаар оролцуулна.

17.5. Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно. Санал болгох бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэнийг харуулах зорилгоор тэдгээрийн техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг техникийн тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой баримт, хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарласан тайлбар ирүүлсэн байна.

- 17.6. Барааг нийлүүлснээс хойш өгөгдлийн хүснэгтэд заасан хугацааны туршид тасралтгүй, горимын дагуу ашиглахад шаардагдах өгөгдлийн хүснэгтэд заасан сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалтыг тэдгээрийг авах боломжтой хаяг, үнийн мэдээллийн хамт ирүүлнэ.
- 17.7. Техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал, тоног төхөөрөмжийн загвар, хэмжих нэгж, стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар зэрэг нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
- 17.8. Гадаадын этгээдийн хувьд гэрээний дагуу хийгдэх техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт;
- 17.9. Монгол Улсын гарал үүсэлтэй бус бараа нийлүүлэхээр санал болгосон оролцогч нь техникийн тодорхойлолтод заасан нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл;
- 17.10. Хуулийн 8.4-т зааснаар давуу эрх тооцуулах барааны Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлснээр Сангийн сайдын баталсан Давуу эрх олгох аргачлал, зааврын дагуу тооцно. Барааны үнийн задаргаанд Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг заагаагүй, эсхүл гарал үүслийг нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх тооцохгүй.
- 17.11. ТШЗ-ны 1.3-т зааснаар нийлүүлэхээр санал болгох бараа Монгол Улсын гарал үүсэлтэй болохыг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ. Нотлох баримт бичиг ирүүлээгүй тохиолдолд тухайн барааг шаардлага хангаагүй гэж үзнэ.
- 17.12. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс нийлүүлэхээр санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

18. Чадавхын болон туршлагын шаардлага

- 18.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

- 18.2. Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн бараа, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 18.3. Түншлэл нь ТШЗ-ны 18.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 18.1-д заасан бол төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 18.4. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

19. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

- 19.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 19.3. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

- 20. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 20.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ.
- 21.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 14-т заасан тендер илгээх маягтад заана.
- 21.4. ТШЗ 21.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.
- 21.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.6. Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- 21.7. Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.8. ТШЗ-ны 21.2-т заасан барааны үнийн задаргааны нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч тендер илгээх маягтад үнээс зөрүүтэй бол барааны үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

- 21.9. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах барааны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 24.1-д зааснаар ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн **Error! Reference source not found.**-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн эцсийн хугацаа авах

- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн тодруулга авах талаар

- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.
- 29.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

- 30. Арифметик залруулах алдааг** 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31. Давуу эрх олгох** 31.1. Захиалагч нь өгөгдлийн хүснэгтэд заасан мэдээлэл, баримт бичгийг ирүүлсэн дотоодын бараанд хуулийн 8.4-т зааснаар давуу эрх олгож, дотоодын барааны хэсгийн үнийг хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 31.3. Давуу эрх авч гэрээ байгуулсан гүйцэтгэгч гэрээний үүрэг гүйцэтгэхэд давуу эрх тооцуулсан нөхцөлийг биелүүлээгүй нь тендер шалгаруулалтад оролцох эрх хязгаарлах нөхцөл болохыг анхаарах шаардлагатай.
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт** 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох** 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.
- 33.2. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
- 33.3. ТШЗ-ны 33.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх** 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах** 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.

- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 19 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. ТШЗ-ны 35.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36. Шийдвэр хүргүүлэх** 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37. Гүйцэтгэлийн баталгаа** 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах** 38.1. Захиалагч ТШЗ-ны 9.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 38.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ӨХ)

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах
ТШЗ 1.1	Тендерийн урилгын дугаар: ЭХЭМҮТ/20240102009

ТШЗ 1.2

Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

Багц №	Багцын нэр
Багц 1	Антибиотик 1
Багц 2	Антибиотик 2
Багц 3	Антибиотик 3 (Дотоод багц)
Багц 4	Антибиотик 4
Багц 5	Антибиотик 5
Багц 6	Антибиотик 6
Багц 7	Бактериофаг, бактер, пробиотикууд
Багц 8	Бүлэгнэлтийн фактор
Багц 9	Умайн булчинд нөлөөлөх эм 1
Багц 10	Умайн булчинд нөлөөлөх эм 2
Багц 11	Умайн булчинд нөлөөлөх эм 3
Багц 12	Умайн булчинд нөлөөлөх эм 4
Багц 13	Өвдөлт намдаах эмүүд 1
Багц 14	Өвдөлт намдаах эмүүд 2
Багц 15	Эмэгтэйчүүдийн лаа
Багц 16	Эмэгтэйчүүдийн бэлдмэл
Багц 17	Дотоодын эм 1
Багц 18	Дотоодын эм 2
Багц 19	Тарилгын шингэн (Дотоод багц)
Багц 20	Нүдний тосон түрхлэг
Багц 21	Нүдний дусаалга 1
Багц 22	Нүдний дусаалга 2
Багц 23	Дусаалга
Багц 24	Арьсны тос, гель
Багц 25	Дархлаа дарангуйлах эмүүд
Багц 26	Дархлаа дарангуйлах эмүүд 2
Багц 27	Хавдрын эсрэг эм 1
Багц 28	Хавдрын эсрэг эм 2
Багц 29	Хавдрын эсрэг эм 3
Багц 30	Ретинопатийн тарилга
Багц 31	Интерлейкин дарангуйлагч
Багц 32	Өнчин эм
Багц 33	Цус бүлэгнэлт, төлжилтийн эмүүд
Багц 34	Бүлэгнэлтэнд нөлөөлөх эмүүд
Багц 35	Мэдээгүйжүүлэг тойрны эмүүд
Багц 36	Дэгдэмхий мэдээгүйжүүлгийн эм 1
Багц 37	Дэгдэмхий мэдээгүйжүүлгийн эм 2
Багц 38	Дотоод шүүрлийн эмгэгийн эмүүд
Багц 39	Гормоны бэлдмэл 1
Багц 40	Гормоны бэлдмэл 2
Багц 41	Уургийн бэлдмэл
Багц 42	Интерферон
Багц 43	Зүрх, судасны эм 1
Багц 44	Зүрх, судасны эмүүд 2
Багц 45	Судсаар тэжээх уусмал 1
Багц 46	Судсаар тэжээх уусмал 2
Багц 47	Мэдрэлийн эмгэгийн эм
Багц 48	Таталтын эсрэг эмүүд
Багц 49	Витамин

Багц 50	Дутуу нярайд хэрэглэх эмүүд
Багц 51	Вирусын эсрэг иммуноглобулин
Багц 52	Амьсгалын эрхтэний эмгэгийн эмүүд
Багц 53	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмүүд
Багц 54	Хоол боловсруулах эрхтэний эмгэгийн эм 1
Багц 55	Хоол боловсруулах эрхтэний эмгэгийн эм 2
Багц 56	Элэгний шилжүүлэх мэс заслын үеийн эмүүд
Багц 57	Тодосгогч бодис 1
Багц 58	Тодосгогч бодис 2
Багц 59	Тодосгогч бодис 3
Багц 60	Бусад эм 1
Багц 61	Бусад эм 2
Багц 62	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 1 (Дотоод багц)
Багц 63	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 2 (Дотоод багц)
Багц 64	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 3 (Дотоод багц)
Багц 65	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 4
Багц 66	Дурангийн ариутгалын бодис
Багц 67	Багаж ариутгах уут, боолт
Багц 68	Ариутгалын тест, багаж угаах хэрэгсэл
Багц 69	Эмнэлгийн хэрэгсэл 1
Багц 70	Эмнэлгийн хэрэгсэл 2
Багц 71	Ургийн мониторын цаас
Багц 72	Ариун самбай (Дотоод багц)
Багц 73	Мэс заслын өмсгөл иж бүрдэл (Дотоод багц)
Багц 74	Кесар хагалгааны иж бүрдэл (Дотоод багц)
Багц 75	Мэс заслын бээлий
Багц 76	Үзлэгийн бээлий
Багц 77	Тариур (Дотоод багц)
Багц 78	Тариур, зүү, гуурс
Багц 79	Дуслын систем 1
Багц 80	Дуслын систем 2
Багц 81	Дижитал рентген хальс 1
Багц 82	Дижитал рентген хальс 2
Багц 83	Мэс заслын наалт
Багц 84	Гуурс 1
Багц 85	Гуурс 2
Багц 86	Гуурс 3
Багц 87	Гуурс 4
Багц 88	Хүчилтөрөгчийн маск, гуурс
Багц 89	Мэдээгүйжүүлгийн маск, хэрэгсэл
Багц 90	Амьсгалын замын хэрэгсэл
Багц 91	Үр хөндөлтийн ажилбарын хэрэгсэл
Багц 92	Биопсийн зүү, хэрэгсэл
Багц 93	Хими эмчилгээний гуурс
Багц 94	Аюулгүйн хайрцаг
Багц 95	Цус тогтоох хэрэгсэл
Багц 96	Элэгний хагалгааны хэрэгсэл 1
Багц 97	Мэс заслын утас 1
Багц 98	Мэс заслын утас 2
Багц 99	Мэс заслын утас 3
Багц 100	Мэс заслын утас 4

Багц 101	Мэс заслын утас 5
Багц 102	Мэс заслын утас 6
Багц 103	Мэс заслын утас 7
Багц 104	Тархины цахилгаан бичлэгийн аппаратын гель
Багц 105	Шүдний материал
Багц 106	Шүдний багаж хэрэгсэл
Багц 107	Эрүү нүүрний гажиг заслын хэрэгсэл
Багц 108	Гемодиализын хэрэгсэл
Багц 109	Диализын тунел гуурс
Багц 110	Хэвлийн диализийн гуурс хэрэгсэл
Багц 111	Нүдний шилний энгийн хасах, хасах цилиндр сфер бэлдэц
Багц 112	Нүдний шилний энгийн нэмэх, хасах цилиндр сфер бэлдэц
Багц 113	Нүдний шилний хүрээ
Багц 114	Эмэгтэйчүүдийн ажилбарын хэрэгсэл 1
Багц 115	Эмэгтэйчүүдийн ажилбарын хэрэгсэл 2
Багц 116	Урогинекологийн хэрэгсэл
Багц 117	Цус тогтоох баллон
Багц 118	Дутуу төрөлтийн тусламж
Багц 119	Ургийн мэс заслын хэрэгсэл
Багц 120	Ерөнхий мэс заслын хэрэгсэл
Багц 121	Дурангийн мэс заслын хэрэгсэл
Багц 122	Тэлэгч баллон, хэрэгсэл
Багц 123	Хүүхдийн дурангийн хэрэгсэл
Багц 124	Ангиографийн хэрэгсэл
Багц 125	Эрүү нүүрний мэс заслын хэрэгсэл
Багц 126	Чих хамар хоолойн мэс заслын хэрэгсэл 1
Багц 127	Чих хамар хоолойн мэс заслын хэрэгсэл 2
Багц 128	Тархины мэс заслын хэрэгсэл
Багц 129	Цээжний мэс заслын хэрэгсэл
Багц 130	Эмэгтэйчүүдийн мэс заслын хэрэгсэл 1
Багц 131	Нүдний мэс заслын хэрэгсэл 1
Багц 132	Нүдний мэс заслын хэрэгсэл 2
Багц 133	Торлогын мэс заслын хэрэгсэл
Багц 134	Нүдний даралт хэмжих аппаратын хэрэгсэл
Багц 135	Бусад хэрэгсэл
Багц 136	Бөөрний мэс заслын хэрэгсэл
Багц 137	Элэгний мэс заслын хэрэгсэл 2
Багц 138	Элэгний мэс заслын хэрэгсэл 3
Багц 139	Элэгний мэс заслын хэрэгсэл 4
Багц 140	Элэгний мэс заслын хэрэгсэл 5
Багц 141	Элэгний мэс заслын хэрэгсэл 6
Багц 142	Эмнэлгийн хэрэгсэл 3
Багц 143	Зүрхний мэс заслын хэрэгсэл
Багц 144	Эмнэлгийн хий
Багц 145	Хяналтын мониторийн хэрэгсэл 1
Багц 146	Хяналтын мониторийн хэрэгсэл 2
Багц 147	Хяналтын мониторийн хэрэгсэл 3
Багц 148	Амьсгалын аппаратны хэрэгсэл 1
Багц 149	Амьсгалын аппаратны хэрэгсэл 2
Багц 150	Амьсгалын аппаратны хэрэгсэл 3
Багц 151	Амьсгалын аппаратны хэрэгсэл 4

	Багц 152	Мэдээгүйжүүлгийн аппаратын хэрэгсэл
	Багц 153	Хүчилтөрөгчийн үйлдвэрийн хэрэгсэл
	Багц 154	Цус, цусан бүтээгдэхүүн
	Багц 155	Вакуумтейнер
	Багц 156	Өвчтөний бугуйвч, хэвлэх төхөөрөмж
	Багц 157	Эмэгтэйчүүдийн мэс заслын хэрэгсэл 2
	Багц 158	Мэс заслын жижиг багаж
	Багц 159	Иммунологи-биохимийн бүрэн автомат анализаторын урвалж
	Багц 160	Иммунологийн бүрэн автомат анализаторийн урвалж -2
	Багц 161	Харшлын шинжилгээний урвал
	Багц 162	Биохимийн бүрэн автомат анализаторын урвалж
	Багц 163	Клиник хими, бүлэгнэлт шинжилгээний бүрэн автомат анализаторийн урвалж
	Багц 164	Шээсний шинжилгээний бүрэн автомат анализаторын урвалж
	Багц 165	Гематологийн бүрэн автомат анализаторийн урвалж
	Багц 166	Микробиологийн урвалж 1
	Багц 167	Микробиологийн урвалж 2
	Багц 168	Бэлгийн замын халдварт өвчин илрүүлэх урвалж
	Багц 169	Дагалдах хэрэгслүүд 1
	Багц 170	Дагалдах хэрэгслүүд 2
	Багц 171	RNA/DNA ялгах болон дагалдах хэрэгслүүд
	Багц 172	Иммунофенотипийн шинжилгээний урвалж
	Багц 173	Иммуногистохимийн урвалж
	Багц 174	Иммуногистохимийн аппаратны хэрэгсэл
	Багц 175	Үргүйдлийн лабораторийн зүү, гуурс
	Багц 176	Үргүйдлийн лабораторийн хэрэгсэл
	Багц 177	Үргүйдлийн лабораторийн урвалж 1
	Багц 178	Иммунологи-биохимийн бүрэн автомат анализаторын урвалж (ҮНҮТ)
	Багц 179	Үр хөврөл өсгөвөрлөх инкубаторын шүүлтүүр
	Багц 180	Пренатал илрүүлэг 1
	Багц 181	Пренатал илрүүлэг 2
	Багц 182	Удамзүйн лабораторийн шинжилгээний урвалж бодис, хэрэгслүүд
	Багц 183	Лабораторийн тоног төхөөрөмжийн хэрэгсэл
ТШЗ 1.3	Дотоод үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич:	
	Багц № 3	Антибиотик 3 (Дотоод багц)
	Багц № 17	Дотоодын эм 1
	Багц № 18	Дотоодын эм 2
	Багц № 19	Тарилгын шингэн (Дотоод багц)
	Багц № 62	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 1 (Дотоод багц)
	Багц № 63	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 2 (Дотоод багц)
	Багц № 64	Ариутгах, халдваргүйжүүлэх бодис 3 (Дотоод багц)
	Багц № 72	Ариун самбай (Дотоод багц)
	Багц № 73	Мэс заслын өмсгөл иж бүрдэл (Дотоод багц)
	Багц № 74	Кесар хагалгааны иж бүрдэл (Дотоод багц)
	Багц № 77	Тариур (Дотоод багц)
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй	

ТШЗ 2.1

Санхүүжилтийн эх үүсвэр нь: ***Эрүүл мэндийн даатгалын сан***

ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 12,144,325,200 (Арван хоёр тэрбум нэг зуун дөчин дөрвөн сая гурван зуун хорин таван мянга хоёр зуун) төгрөг	
	Багц №	Багцын төсөвт өртөг (₮)
	Багц 1	6,061,100.00 Зургаан сая жаран нэгэн мянга нэг зуун төгрөг
	Багц 2	22,951,400.00 Хорин хоёр сая есөн зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун төгрөг
	Багц 3	7,930,355.00 Долоон сая есөн зуун гучин мянга гурван зуун тавин таван төгрөг
	Багц 4	3,919,500.00 Гурван сая есөн зуун арван есөн мянга таван зуун төгрөг
	Багц 5	180,000,000.00 Зуун наян сая төгрөг
	Багц 6	2,553,000.00 Хоёр сая таван зуун тавин гурван мянган төгрөг
	Багц 7	40,626,000.00 Дөчин сая зургаан зуун хорин зургаан мянган төгрөг
	Багц 8	105,720,000.00 Зуун таван сая долоон зуун хорин мянган төгрөг
	Багц 9	20,620,800.00 Хорин сая зургаан зуун хорин мянга найман зуун төгрөг
	Багц 10	72,576,000.00 Далан хоёр сая таван зуун далан зургаан мянган төгрөг
	Багц 11	72,000,000.00 Далан хоёр сая төгрөг
	Багц 12	16,128,000.00 Арван зургаан сая нэг зуун хорин найман мянган төгрөг
	Багц 13	33,639,700.00 Гучин гурван сая зургаан зуун гучин есөн мянга долоон зуун төгрөг
	Багц 14	35,820,000.00 Гучин таван мянга найман зуун хорин мянган төгрөг
	Багц 15	15,342,020.00 Арван таван сая гурван зуун дөчин хоёр мянга хорин төгрөг
	Багц 16	9,600.00 Есөн мянга зургаан зуун төгрөг
	Багц 17	7,254,000.00 Долоон сая хоёр зуун тавин дөрвөн мянган төгрөг
	Багц 18	75,139,125.00 Далан таван сая нэг зуун гучин есөн мянга нэг зуун хорин таван төгрөг
	Багц 19	110,141,380.00 Зуун арван сая нэг зуун дөчин нэгэн мянга гурван зуун наян төгрөг
	Багц 20	2,369,000.00 Хоёр сая гурван зуун жаран есөн мянган төгрөг
	Багц 21	8,665,800.00 Найман сая зургаан зуун жаран таван мянга найман зуун төгрөг
	Багц 22	6,891,800.00 Зургаан сая найман зуун ерэн нэгэн мянга найман зуун төгрөг
	Багц 23	2,784,710.00 Хоёр сая долоон зуун наян дөрвөн мянга долоон зуун арван төгрөг
	Багц 24	5,701,300.00 Таван сая долоон зуун нэг мянга гурван зуун төгрөг
	Багц 25	8,060,000.00 Найман сая жаран мянган төгрөг
Багц 26	16,945,000.00 Арван зургаан сая есөн зуун дөчин таван мянган төгрөг	

Багц 27	98,744,600.00	Ерэн найман мянга долоон зуун дөчин дөрвөн мянга зургаан зуун төгрөг
Багц 28	111,000,000.00	Зуун арван нэгэн сая төгрөг
Багц 29	34,520,000.00	Гучин дөрвөн сая таван зуун хорин мянган төгрөг
Багц 30	5,600,000.00	Таван сая зургаан зуун мянган төгрөг
Багц 31	41,834,160.00	Дөчин нэгэн сая найман зуун гучин дөрвөн мянга нэг зуун жаран мянган төгрөг
Багц 32	54,900.00	Тавин дөрвөн мянга есөн зуун төгрөг
Багц 33	41,861,000.00	Дөчин нэгэн сая найман зуун жаран нэгэн мянган төгрөг
Багц 34	58,163,200.00	Тавин найман сая нэг зуун жаран гурван мянга хоёр зуун төгрөг
Багц 35	17,946,000.00	Арван долоон сая есөн зуун дөчин зургаан мянган төгрөг
Багц 36	180,000,000.00	Зуун наян сая төгрөг
Багц 37	19,200,000.00	Арван есөн сая хоёр зуун мянган төгрөг
Багц 38	275,838,000.00	Хоёр зуун далан таван сая найман зуун гучин найман мянган төгрөг
Багц 39	47,157,330.00	Дөчин долоон сая нэг зуун тавин долоон мянга гурван зуун гучин төгрөг
Багц 40	15,400.00	Арван таван мянга дөрвөн зуун төгрөг
Багц 41	79,200,000.00	Далан есөн сая хоёр зуун мянган төгрөг
Багц 42	6,845,000.00	Зургаан сая найман зуун дөчин таван мянган төгрөг
Багц 43	19,547,000.00	Арван есөн сая таван зуун дөчин долоон мянган төгрөг
Багц 44	24,283,200.00	Хорин дөрвөн сая хоёр зуун наян гурван мянга хоёр зуун төгрөг
Багц 45	126,293,000.00	Зуун хорин зургаан сая хоёр зуун ерэн гурван мянган төгрөг
Багц 46	41,448,000.00	Дөчин нэгэн сая дөрвөн зуун дөчин найман мянган төгрөг
Багц 47	31,921,600.00	Гучин нэгэн сая есөн зуун хорин нэгэн янга зургаан зуун төгрөг
Багц 48	18,177,000.00	Арван найман сая нэг зуун далан долоон мянган төгрөг
Багц 49	3,578,800.00	Гурван сая таван зуун далан найман мянга найман зуун төгрөг
Багц 50	254,460,000.00	Хоёр зуун тавин дөрвөн сая дөрвөн зуун жаран мянган төгрөг
Багц 51	37,000,000.00	Гучин долоон сая төгрөг
Багц 52	16,482,800.00	Арван зургаан сая дөрвөн зуун наян хоёр мянга найман зуун төгрөг
Багц 53	11,139,000.00	Арван нэгэн сая нэг зуун гучин есөн мянган төгрөг
Багц 54	73,106,250.00	Далан гурван сая нэг зуун зургаан мянга хоёр зуун тавин төгрөг
Багц 55	90,288,200.00	Ерэн сая хоёр зуун наян найман мянга хоёр зуун төгрөг
Багц 56	7,700,000.00	Долоон сая долоон зуун мянган төгрөг

Багц 57	52,440,000.00	Тавин хоёр сая дөрвөн зуун дөчин мянган төгрөг
Багц 58	18,432,000.00	Арван найман сая дөрвөн зуун гучин хоёр мянган төгрөг
Багц 59	18,720,000.00	Арван найман сая долоон зуун хорин мянган төгрөг
Багц 60	89,088,600.00	Наян есөн сая наян найман мянга зургаан зуун төгрөг
Багц 61	1,400.00	Мянга дөрвөн зуун төгрөг
Багц 62	110,610,000.00	Зуун арван сая зургаан зуун арван мянган төгрөг
Багц 63	80,368,000.00	Наян сая гурван зуун жаран найман мянган төгрөг
Багц 64	34,175,200.00	Гучин дөрвөн сая нэг зуун далан таван мянга хоёр зуун төгрөг
Багц 65	62,806,500.00	Жаран хоёр сая найман зуун зургаан мянга таван зуун төгрөг
Багц 66	16,850,000.00	Арван зургаан сая найман зуун тавин мянган төгрөг
Багц 67	24,477,150.00	Хорин дөрвөн сая дөрвөн зуун далан долоон мянган нэг зуун тавин төгрөг
Багц 68	8,400,000.00	Найман сая дөрвөн зуун мянган төгрөг
Багц 69	56,232,900.00	Тавин зургаан сая хоёр зуун гучин хоёр сая есөн зуун төгрөг
Багц 70	108,062,950.00	Зуун найман сая жаран хоёр мянга есөн зуун тавин төгрөг
Багц 71	15,282,000.00	Арван таван сая хоёр зуун наян хоёр мянган төгрөг
Багц 72	505,420,000.00	Таван зуун таван сая дөрвөн зуун хорин мянган төгрөг
Багц 73	312,004,000.00	Гурван зуун арван хоёр сая дөрвөн мянган төгрөг
Багц 74	159,500,000.00	Зуун тавин есөн сая таван зуун мянган төгрөг
Багц 75	195,000,000.00	Зуун ерэн таван сая төгрөг
Багц 76	276,100,000.00	Хоёр зуун далан зургаан сая нэг зуун мянган төгрөг
Багц 77	384,289,800.00	Гурван зуун наян дөрвөн сая хоёр зуун наян есөн мянга найман зуун төгрөг
Багц 78	136,757,100.00	Зуун гучин зургаан сая долоон зуун тавин долоон мянга нэг зуун төгрөг
Багц 79	181,353,000.00	Зуун наян нэгэн сая гурван зуун тавин гурван мянган төгрөг
Багц 80	25,200,000.00	Хорин таван сая хоёр зуун мянган төгрөг
Багц 81	24,688,000.00	Хорин дөрвөн сая зургаан зуун наян найман мянган төгрөг
Багц 82	31,053,000.00	Гучин нэгэн сая тавин гурван мянган төгрөг
Багц 83	47,186,600.00	Дөчин долоон сая нэг зуун наян зургаан мянга зургаан зуун төгрөг
Багц 84	66,171,350.00	Жаран зургаан сая нэг зуун далан нэгэн мянга гурван зуун тавин төгрөг

Багц 85	19,908,000.00	Арван есөн сая есөн зуун найман мянган төгрөг
Багц 86	53,681,120.00	Тавин гурван мянга зургаан зуун наян нэгэн мянга нэг зуун хорин төгрөг
Багц 87	13,882,635.00	Арван гурван сая найман зуун наян хоёр мянга зургаан зуун гучин таван төгрөг
Багц 88	45,470,100.00	Дөчин таван сая дөрвөн зуун далан мянга нэг зуун төгрөг
Багц 89	66,632,000.00	Жаран зургаан сая зургаан зуун гучин хоёр мянган төгрөг
Багц 90	40,554,000.00	Дөчин сая таван зуун тавин дөрвөн мянган төгрөг
Багц 91	202,061,100.00	Хоёр зуун хоёр сая жаран нэгэн мянга нэг зуун төгрөг
Багц 92	23,109,000.00	Хорин гурван сая нэг зуун есөн мянган төгрөг
Багц 93	2,700,000.00	Хоёр сая долоон зуун мянган төгрөг
Багц 94	51,840,000.00	Тавин нэгэн сая найман зуун дөчин мянган төгрөг
Багц 95	6,145,000.00	Зургаан сая нэг зуун дөчин таван мянган төгрөг
Багц 96	30,180,000.00	Гучин сая нэг зуун наян мянган төгрөг
Багц 97	60,571,830.00	Жаран сая таван зуун далан нэгэн мянган найман зуун гучин төгрөг
Багц 98	56,840,000.00	Тавин зургаан сая найман зуун дөчин мянган төгрөг
Багц 99	23,091,000.00	Хорин гурван сая ерэн нэгэн мянган төгрөг
Багц 100	18,920,000.00	Аран найман сая есөн зуун хорин мянган төгрөг
Багц 101	7,004,000.00	Долоон сая дөрвөн мянган төгрөг
Багц 102	18,742,000.00	Арван найман сая долоон зуун дөчин хоёр мянган төгрөг
Багц 103	8,170,000.00	Найман сая нэг зуун далан мянган төгрөг
Багц 104	2,500,000.00	Хоёр сая таван зуун мянган төгрөг
Багц 105	32,189,200.00	Гучин хоёр сая нэг зуун наян есөн мянган төгрөг
Багц 106	4,596,400.00	Дөрвөн сая таван зуун ерөн зургаан мянга дөрвөн зуун төгрөг
Багц 107	20,052,900.00	Хорин сая тавин хоёр мянга есөн зуун төгрөг
Багц 108	191,614,000.00	Нэг зуун ерөн нэгэн сая зургаан зуун арван дөрвөн мянган төгрөг
Багц 109	6,000,000.00	Зургаан сая төгрөг
Багц 110	1,946,800.00	Нэг сая есөн зуун дөчин зургаан мянга найман зуун төгрөг
Багц 111	12,040,000.00	Арван хоёр сая дөчин мянган төгрөг
Багц 112	6,080,000.00	Зургаан сая наян мянган төгрөг
Багц 113	3,840,000.00	Гурван сая найман зуун дөчин мянган төгрөг
Багц 114	1,560,000.00	Нэг сая таван зуун жаран мянган төгрөг
Багц 115	8,700,000.00	Найман сая долоон зуун мянган төгрөг
Багц 116	7,200,000.00	Долоон сая хоёр зуун мянган төгрөг

Багц 117	750,000.00	Долоон зуун тавин мянган төгрөг
Багц 118	960,000.00	Есөн зуун жаран мянган төгрөг
Багц 119	125,900.00	Нэг зуун хорин таван мянга есөн зуун төгрөг
Багц 120	249,067,000.00	Хоёр зуун дөчин есөн сая жаран долоон мянган төгрөг
Багц 121	117,956,000.00	Нэг зуун арван долоон сая есөн зуун тавин зургаан мянган төгрөг
Багц 122	309,780,000.00	Гурван зуун есөн сая долоон зуун наян мянган төгрөг
Багц 123	43,090,000.00	Дөчин гурван сая ерөн мянган төгрөг
Багц 124	413,290,000.00	Дөрвөн зуун арван гурван сая хоёр зуун ерөн мянган төгрөг
Багц 125	17,122,100.00	Арван долоон сая нэг зуун хорин хоёр мянга нэг зуун төгрөг
Багц 126	303,968,000.00	Гурван зуун гурван сая есөн зуун жаран найман мянган төгрөг
Багц 127	191,585,000.00	Нэг зуун ерөн нэгэн сая таван зуун наян таван мянган төгрөг
Багц 128	18,000,000.00	Арван найман сая төгрөг
Багц 129	125,880,000.00	Нэг зуун хорин таван сая найман зуун наян мянган төгрөг
Багц 130	8,016,000.00	Найман сая арван зургаан мянган төгрөг
Багц 131	110,065,560.00	Нэг зуун арван сая жаран таван мянга таван зуун жараг төгрөг
Багц 132	10,142,200.00	Арван сая нэг зуун дөчин хоёр мянга хоёр зуун төгрөг
Багц 133	131,923,000.00	Нэг зуун гучин нэгэн сая есөн зуун хорин гурван мянган төгрөг
Багц 134	3,190,000.00	Гурван сая нэг зуун ерөн мянган төгрөг
Багц 135	2,710,000.00	Хоёр сая долоон зуун арван мянган төгрөг
Багц 136	44,980,000.00	Дөчин дөрвөн сая есөн зуун наян мянган төгрөг
Багц 137	7,356,000.00	Долоон сая гурван зуун тавин зургаан мянган төгрөг
Багц 138	22,300,000.00	Хорин хоёр сая гурван зуун мянган төгрөг
Багц 139	38,400,100.00	Гучин найман сая дөрвөн дуун мянга нэг зуун төгрөг
Багц 140	27,423,000.00	Хорин долоон сая дөрвөн зуун хорин гурван мянган төгрөг
Багц 141	2,320,000.00	Хоёр сая гурван зуун хорин мянган төгрөг
Багц 142	10,271,400.00	Арван сая хоёр зуун далан нэгэн мянга дөрвөн зуун төгрөг
Багц 143	157,538,700.00	Нэг зуун тавин долоон сая таван зуун гучин найман мянга долоон зуун төгрөг
Багц 144	8,900,000.00	Найман сая есөн зуун мянган төгрөг
Багц 145	23,096,000.00	Хорин гурван сая ерөн зургаан мянган төгрөг
Багц 146	7,294,600.00	Долоон сая хоёр зуун ерөн дөрвөн мянган зургаан зуун төгрөг
Багц 147	3,005,000.00	Гурван сая төгрөг таван мянган төгрөг
Багц 148	9,840,000.00	Есөн сая найман зуун дөчин мянган төгрөг

Багц 149	14,400,000.00	Арван дөрвөн сая дөрвөн зуун мянган төгрөг
Багц 150	35,922,000.00	Гучин таван сая есөн зуун хорин хоёр мянган төгрөг
Багц 151	2,415,000.00	Хоёр сая дөрвөн зуун арван таван мянган төгрөг
Багц 152	4,494,000.00	Дөрвөн сая дөрвөн зуун ерөн дөрвөн мянган төгрөг
Багц 153	14,070,000.00	Арван дөрвөн сая далан мянган төгрөг
Багц 154	25,455,000.00	Хорин таван сая дөрвөн зуун тавин таван мянган төгрөг
Багц 155	36,441,000.00	Гучин зургаан сая дөрвөн зуун дөчин нэгэн мянган төгрөг
Багц 156	55,400,000.00	Тавин таван сая дөрвөн зуун мянган төгрөг
Багц 157	3,200.00	Гурван мянга хоёр зуун төгрөг
Багц 158	11,200.00	Арван нэгэн мянга хоёр зуун төгрөг
Багц 159	432,381,140.00	Дөрвөн зуун гучин хоёр сая гурван зуун наян нэгэн мянга нэг зуун дөчин төгрөг
Багц 160	180,756,000.00	Нэг зуун наян сая долоон зуун тавин зургаан мянган төгрөг
Багц 161	6,800,000.00	Зургаан сая найман зуун мянган төгрөг
Багц 162	424,656,861.00	Дөрвөн зуун хорин дөрвөн сая зургаан зуун тавин зургаан мянга найман зуун жаран нэгэн төгрөг
Багц 163	298,111,054.00	Хоёр зуун ерөн найман сая нэг зуун арван нэгэн мянга тавин дөрвөн төгрөг
Багц 164	62,338,866.00	Жаран хоёр сая гурван зуун зучин найман мянга найман зуун жаран зургаан төгрөг
Багц 165	152,173,148.00	Нэг зуун тавин хоёр сая нэг зуун далан гурван мянга нэг зуун дөчин найман төгрөг
Багц 166	90,597,800.00	Ерөн сая таван зуун ерөн долоон мянга найман зуун төгрөг
Багц 167	41,796,130.00	Дөчин нэгэн сая долоон зуун ерөн зургаан мянга нэг зуун гучин төгрөг
Багц 168	21,715,000.00	Хорин нэгэн сая долоон зуун арван таван мянган төгрөг
Багц 169	42,886,500.00	Дөчин хоёр сая найман зуун наян зургаан мянга таван зуун төгрөг
Багц 170	5,840,000.00	Таван сая найман зуун дөчин мянган төгрөг
Багц 171	2,935,500.00	Хоёр сая есөн зуун гучин таван мянга таван зуун төгрөг
Багц 172	339,873,771.00	Гурван зуун гучин есөн сая найман зуун далан гурван мянга долоо зуун далан нэгэн төгрөг
Багц 173	88,152,319.00	Наян найман сая нэг зуун тавин хоёр мянга гурван зуун арван есөн төгрөг
Багц 174	2,663,000.00	Хоёр сая зургаан зуун жаран гурван мянган төгрөг
Багц 175	43,438,000.00	Дөчин гурван сая дөрвөн зуун гучин найман мянган төгрөг
Багц 176	28,336,800.00	Хорин найман сая гурван зуун гучин зургаан мянга найман зуун төгрөг

	Багц 177	65,694,000.00	Жаран таван сая зургаан зуун ерэн дөрвөн мянган төгрөг
	Багц 178	39,152,215.00	Гучин есөн сая нэг зуун тавин хоёр мянга хоёр зуун арван таван төгрөг
